



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/167

Хэрлэн сум

Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан
сэргийлэх ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 2017 оны 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулахад 1,960,000 (нэг сая есөн зуун жаран мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Ард иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д даалгасугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

سپین سلیس م
سرسر ستمنزآ ندر سرسری



۳/۶/۶۶
فمنس

نخستین هیئت

۲۵ ۳۵ ۵۵
بهر و ...

ناتین رهنمایان در سطح ...
... و ...

...
...
...
...

...
...
...

...
...

...
...
...

...
...
...
...

...
...
...
...

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 28 -ний өдрийн
А/164 дугаар захирамжийн хавсралт

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Нэр төрөл	Хэмжээ/м/	Тоо ширхэг	Нэгж үнэ/төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	Уриалга бүхий зурагт самбар болон хүрээ	1.5 м2	9	90000	810.000
2	Витаминтай сэрэмжлүүлэг /витамин/	-	500	800	400.000
3	Тараах материал	A5	500	1500	750.000
Нийт					1.960.000